



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 480

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2016, 2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Өвөрхангай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Лхам-Оролмаад дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

2.2. Худалдан авах ажиллагааны зөрчил, дутагдал гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

2.3. Компанийн хөрөнгийг зохистой удирдах, авлага, өглөгийг бууруулах, хугацаа хэтэрсэн авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх;

2.4. Ашиглалтгүй байгаа үндсэн хөрөнгийг худалдах болон шилжүүлэх асуудлыг судалж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.5. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах болон энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах, биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б. ГАВАА

000240

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 3Q дугаар сарын 3Q-ний өдрийн
780 дугаар тогтоолын хавсралт

“Өвөрхангай АЗЗА” төрийн өмчтөд хувьцаат компанийн шалгалтаар илэрсэн
зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

| Д/д | Зөрчил, дутагдлын утга | Хариуцах эзэн | Дүн /төгрөгөөр/ | Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ |
|-----|---|---------------------------------------|-----------------|--|
| 1 | Аудитын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн “Ньюбаланс аудит” ХХК нь компанийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагаар баталгаажуулаагүй хүлээлгэн өгсөн зөрчил | Гүйцэтгэх захираг, Санхүүгийн алба | - | Компанийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу санхүүгийн талаанд аудит хийх аудитын компанийг сонгож, Үндэсний аудитын газарт аудитын зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах талаар мэдэгдэж, холбогдох зөвшөөрлийг авсны үндсэн дээр гурван талын гэрээ байгуулж ажиллах. |
| 2 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон 2017 оны Сангийн сайдын 393 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг тайланг”-ын дагуу худалдан авах ажиллагааны телөвлөгөө тайланг шаардлагын түвшинд боловсруулж эрх бүхий байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлээгүй | Гүйцэтгэх захираг, Санхүүгийн алба | - | Худалдан авах ажиллагааны телөвлөгөө, зохион байгуулалт, тайланг хуулийн дагуу хэрэгжүүлэх, телөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт хийхгүй байх, нийт төсөвт өрттийг үндэслэх, жишиг баримт бичийг ашиглах. |
| | | | | Зөрчил, дутагдлын нийт дүн |